ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 08 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2021.08.25 **Дархан**

1. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Дархан сумын тайлан

- Дархан сумын нутаг дэвсгэрт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилж аваагүй тухай лавлагааг нийт 61 иргэнд гаргаж өгсөн.
- Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрыг хамтран өмчлөх эрхээ хүчингүй болгуулж шинээр газар өмчлөх эрхийг сэргээлгэх хүсэлт гаргасан 32 иргэн, хуулийн этгээдийн кадастрын зургийг тус тус гаргаж өгсөн.
- Э дугаар ирсэн 32 иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших гэрээг байгуулан гэрчилгээг олгосон.

УБХ-руу Э дугаар авахаар 41 иргэн хулийн этгээдийн холбогдох мэдээллийг илгээсэн.

- 7 иргэн хуулийн этгээдийн эзэмшил өмчлөлийн газартай эсэх лавалгааг Цагдаагийн газарт гаргаж өгсөн.
- Зөвшөөрөлгүй хашаа татсан 4, хашаа барьсан 1 иргэнд шаардах хуудас өгч ажилласан.

- Худалдах худалдан авах эрхээр газар өмчилж авахыг хүссэн 106 иргэний эрхийг шилуүүлэн ажилласан
- Зээлийн барьцааны 22 бүртгэл хийж ажилласан.
- Шинэчилсэн бүртгэл 16 иргэний мэдээллийг оруулан ажилласан.
- Газар эзэмшүүлэх дуудлага худалдааг зохион байгуулан ажилласан. /оролцогч ирээгүй/

Дархан сумын засаг даргын тамгын газраас ирсэн албан тоотын дагуу 4 дүгээр багт байрлах гражын газрын граж эзэмшигчдийн судалгааг гаргасан.

2. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Барилга байгууламжийн ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулсан талаар:

- Засгийн газрын 2018 оны 317-р тогтоолоор батлагдсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм, Дархан-Уул аймгийн засаг даргын 2019 оны 01-А/26 тоот томилогдсон захирамжийн дагуу барилгын техникийн бичиг баримтыг хянаж үзэн ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Үүнд:

    1. Шарын гол сумын Шинэ орчин хотхонд баригдах эхний ээлжийн гадна дулааны шугамын ажлын барилга

2. Хонгор суманд байрлалтай “Бласт эксперт инженеринг” ХХК-ний тэсрэх материал хадгалах агуулахын барилга

- Засгийн газрын 2018 оны 68, 171 дүгээр тогтоолын дагуу барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 3 барилга байгууламжид олгосон. Үүнд:

- Дархан сум, 13-р баг "Монсуль" ХХК-ний ШТС-ын барилга
- Дархан сум, 14-р баг Хүүхдийн төмөр замын цогцолборын өртөө, депогийн барилга
- Дархан сум МОН-3244/3245 төслийн хүрээнд хийгдэх үйлдвэрийн бохир усны шугамын А1 хэсгийн өөрчлөлтийн ажил

- Дархан-Уул аймгийн хэмжээнд баригдаж байгаа барилга байгууламжид угсралтын явцад нь хяналт шалгалтыг Аймгийн Мэргэжлийн хяналттай газартай хамтран 15 барилгад хэрэгжүүлсэн.

- **Ирүүлсэн албан бичигт хариу өгсөн талаар:**
  - Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст Дархан-Уул аймгийг 2022 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах саналыг манай байгууллагаас боловсруулан хавсралтаар хүргүүлсэн.
  - Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р багт байрлалтай “Хатан дулам” ХХК-ний эмнэлэгийн зориулалттай барилгад барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл хүссэний дагуу хянаж үзэхэд зураг төслийн магадлалын ерөнхий дүгнэлт дутуу байсан зөвшөөрлийг олгох боломжгүй тухай албан бичгийг хүргүүлсэн.
  - “ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-с ирүүлсэн Дархан-Уул аймаг, Дархан сум, Малчин багийн Дархан-2 төмөр замын өртөөний баруун талд байрлах үнсэн сан сэргээн байгуулах ажилд барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл хүссэн албан бичиг ирүүлсэн. Энэхүү үнсэн далан сэргээн байгуулах ажил нь Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 12-р сарын 31-ны өдрийн 218 дугаар тушаалын бага, дунд, өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн ангилалд хамрагдахгүй тул үнсэн далан сэргээн байгуулах ажил нь инженерийн

ямар нэгэн хийцлэлгүй тул маней байгууллагаас барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авах шаарлагагүй тухай албан бичгийг хүргүүлсэн.

Хот байгуулалтын кадастр, зурагт төслийн чиглэл:

- Дархан сум, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх талбайн тохижилт, тоглоомын талбай, авто зам засварлах зэрэг газруудын 13 байршилд зураг
- Архитектур төлөвлөлтын даалгавар 5, барилгын ажил эхлүүлэх, үргэлжүүлэх хүсэлтийн дагуу цахим системд 4 ААН, иргэний хүсэлтийг бүртгэлжүүлж оруулав.



- Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн нөхөн бүрдүүлэлтэнд 101 барилга байгууламж, объектын фото зураг 4 талаас харсан.
- Өөрт цохогдсон ААН, иргэний хүсэлтийг цаг тухайд нь шийдвэрлэж ажиллаа.



Барилгын материал үйлдвэрлэл, лабораторийн чиглэл:

- Барилга хот байгуулалтын яам, Барилга хөгжлийн төв, Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоонд 2021 оны эхний хагас жилийн мэдээг нэгтгэн 33 хуудас бүхий 2021.08.12-ны №459 тоотоор хүргүүлэв. 18 ААНБ-аас мэдээ ирүүлэв. Тус мэдээнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо хэмжээ болон борлуулалтын үнийн мэлээ, ашиглагдаж буй машин механизм, ажилчдын тоо, зарцуулсан цалингийн хэмжээ бүхий мэдээдэл багтана.


БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТЫН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ЭЦСИЙН МЭДЭЭ

I. ХАЯГИЙН МЭДЭЭЛЭЛ

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	" " ХХК	
Регистрийн дугаар		
ААНБ-ын байршил	Нэр	Код
Аймаг нийслэл	Дархан-Уул аймаг	
Сум, дүүрэг	Даркан	
Үйлдвэрийн байршил	Нэр	Код
Аймаг нийслэл	Дархан-Уул аймаг	
Сум, дүүрэг	Даркан	
Баг, хороо	...-р баг	
Утас	7037	
Гар утас	99	
И-мэйл хаяг	@	
Үйлдвэр байгуулагдсан огноо	20	
Хаягийн хэлбэр	ХХК	1 1
Өмчийн хэлбэр	Хувийн	2 1
Үйл ажиллагаанд чиглэл	Бүт	

1. Аж ахуйн нэгж, байгууллага тайлант оны эхний хагас жилийн мэдээг 7 дугаар сарын 20-нд, жилийн мэдээг дараа оны 2 дугаар сарын 21-нд Барилгын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагуудад цахим хэлбэрээр ирүүлнэ.

2. Барилгын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллага тайлант оны эхний хагас жилийн мэдээг 7 дугаар сарын 25-нд, жилийн мэдээг дараа оны 2 дугаар сарын 25-нд Барилгын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

3. Барилгын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага тайлант оны эхний хагас жилийн мэдээг 7 дугаар сарын 30-нд, жилийн мэдээг дараа оны 3 дугаар сарын 4-нд Үндэсний статистикийн хороонд хүргүүлнэ.

II. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Барилга, хот байгуулалтын сайд Үндэсний Статистикийн Хорооны даргын 2019 оны 12 дугаар сарын 18-ны 206/А/184 дугаар хамтарсан тушаалын 9 дүгээр хавсралт

3-БМ-2

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЛТЫН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ЭЦСИЙН МЭДЭЭ

2. Ерөнхий мэдээлэл

(мсөн дүнгээр)

№	Ашигт малтмалын нэр	Хэм хэмж нэгж	Олборлосон ашигт малтмал		Борлуулсан ашигт малтмал		Ашиглалтын лицензийн дугаар	Зөвшөөрөл авсан талбайн хэмжээ (га)	Ашиглалтын явцад эвдэлд орсон газрын хэмжээ (га)	Нөхөн сэргээлт хийсэн		
			Бөөгнөсөн хэмжээ	Үнийн дүн (мянган төг)	Бөөгнөсөн хэмжээ	Үнийн дүн (мянган төг)				Талбай (га)	Зардуулсан зардал (мянган төг)	
	А	Б	В	2	3	4			5	6	7	
1	Элс	МЗ	6,513	75,217.20	3,061	50,241.60	ДА-004А	90.78	-			Анто-Од
2	Дайрга	МЗ	2,124	18,138.60	4,472	35,596.50	ДА-005А	30	-			
1	Шавар	тн	1600	1,920.0	0	-	А1804	27	2	0.5	3,900.0	Тэгх хан ХХК
1	Шохойн чулуу	м³					14949А	24.90	2021 онд олборлолт байгуй гэж, хуулдаж авдаг			Силикат ХХК
1	Төмрийн хүдрийн баяжмал	тн	1846358	43,631,011.0	77295	99,054,146.0	013319					Дарханы тамирлалийн үйлдвэр ХК
1	Төмрийн хүдрийн баяжмал	тн	513643	14,746,818.0	534239	81,154,738.0	010738					
1	Хайрга	м³	4440	65,659.0	2180	33,924.0	6,725	37.00	0.2	0.20	1,500.0	Даркан Карьер ХХК
2	уулын чулуу	м3	10100	123,430.0	4817	66,392.0	5806А	46	0.1	0.1	1,000.0	
1	Их Булантын элс	м³	1645	18,095.0	1285	14,135.0	МВ017362	100.53	11.6	0.76	35,080.0	Сонголон хайрхан ХХК
1	Шохойн чулуу	тн	5435	84,134.4	6150	111,313.8	А4658	30.78	3	0.5	1,500.0	Идэр Хайхан ХХК
	БҮГД			58,764,423.2		180,520,486.9					42,980.0	
1	элс хайрга	тн	64.6	726,887.2	64.6	899,438.6	А8207	28	0.2	0.1	3,300.0	Тушиг уул ХХК

Үйлдвэрийн үнэ чадал, бөөгнөсөн хэмжээгээр	Ажилбарын дугаар	Тайлант хугацаанд Бөөгнөсөн хэмжээ	Тайлант хугацаанд Үнийн дүн /мянган төг/	Тайлант хугацаанд Бөөгнөсөн хэмжээ /м3/	Тайлант хугацаанд Үнийн дүн /мянган төг/	ААНБ
2	3	4	5	6	7	8
60		6,513	75,217.20	3,061	50,241.60	Анто Од ХХК
60		2,124	18,138.60	4,472	35,596.50	
120		3,642.0	688,050.6	3,642.0	651,397.1	
онгоц = 30ш	МУ-4.1	650ш	146250.0	650ш	146250.0	Бурхант Хэсаат ХХК
онгоц = 12ш	МУ-4.1	30ш3	1500.0	30ш3	1500.0	
онгоц = 100ш	МУ-4.1	1300ш	7800.0	1300ш	7800.0	
	М.У-4.1	14.7786	11,825.7	12.8309	18,411.3	МӨНХ-ОДЦАЦРАЛ
	М.У-4.1	59.433	19,185.0	39.245	14,383.0	
	М.У-4.1	94.484	30,090.7	52.0879	4,023.0	
	М.У-4.1	3	2,310.0	4.94	3,311.0	
	М.У-4.1			1.1076	1,314.0	
	М.У-4.1	68.753	68,240.1	56.782	55,715.7	
онгоц = 23тн		3076.56	288,860.80	3404.71	311,690.0	Тулгат Шөнгөр ХХК
1ц=40м3		9300	88,180.6	11056	109,101.4	Идэр хайрхан ХХК
ад = 1800000ш		112200	36,465.0	33125	13,250.0	Тэгшхан ХХК
ацт = 60куб		5186	832,737.5	5186	832,737.5	Стандарт стийл ХХК
		99	11,880.0	99	11,880.0	Их торгоны зам ХХК
			-		-	
		19	2,660.0	19	2,660.0	
		202	30,300.0	202	30,300.0	
			-		-	

- 2021.08.18-нд 14:00 цагт / арматур / цахим хурал болов. Цахим хуралд УИХ-ын Төсвийн байнгын хорооны ажлын алба Гишүүн Энхтүвшин холбогдлоо. БМҮХолбооноос Бямбажав /88983717/ оролцов. /1тн арматур 3.1 сая төгрөгийн үнэтэй, Налайхын үйлдвэрийн 1 тн арматурийн үнэ 2.7 сая байна/. /Цахилгааны үнийг хөнгөлбөл 2.550.0 мян төг болох боломжтой/ Дарханы Төмөлөгийн үйлдвэр ХК, Хатуу төмөр ХХК-ууд оролцож **3 асуудлыг хэлэлцэв. Үүнд:**

1 Импортын хамаарал багасгах
2 Арматур эрхчим хүчний хөнгөлөлөөнд хамрагдах /Түүхий нүүрс түлүүлэхгүй байх/ 1кВт 26075 төг
3 3 хувийн зээлд хамрагдах байдал

3. ЗАХИРГАА УДИРДЛАГЫН АЖИЛ:

Сургалтын чиглэлээр:

- Аймгийн ЗДТГ-аас хяналт-шинжилгээ үнэлгээ хийх ажлын удирдамжын дагуу албан даалгаврын хүрээнд төрийн албан хаагчдыг үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээний чиглэлээр цахим сургалтад бүх албан хаагчдыг https://training-mongolia.thinkific.com/ сайтаар хамруулхаар ажиллаж байна.

Хүний нөөц, дотоод ажил:

- Нийт 20 албан хаагчдаас 12 албан хаагчид ээлжийн амралтыг эдлэн эргэн ажилдаа орсон, 8 дугаар сард 7 албан хаагч ээлжийн амралттай байна. 1 албан хаагч 9 дүгээр сард ээлжийн амралтаа авна.
- Ковид-19 халдвараар ГУХэлтсээс-2, ЗУХэлтсээс-2 албан хаагч тусгаарлах байранд хэвтэн эмчлүүлж байна, тэдгээр албан хаагчдын ажлыг нь бусад албан хаагчдад хуваарилан ажиллаж байна.

Бусад ажлууд:

- “Дархан хотын 60 жил”-ийн ойн арга хэмжээний хүрээнд бүтээлч ажлын нэг болох 282 метр урттай “Дүүжин гүүр”-ний өнгө будгийг сэргээж будсан үйл ажиллагаанд ГХБХБГ-аас хяналт тавьж НААҮГ, Вилла Бридж ХХК-тай ажилласан.

- Нийт албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг хангуулж, баяжилтыг хийж, хүний нөөцийн мэдээллийн системд шинэчлэл хийж ажиллаж байна.
- Аймгийн ЗДТГ-аас ТЗУХэлтсийн дарга Б.Баярсайхан даргаар ахлуулсан “төрийн байгууллагуудад зөвлөн туслах чиглэл”-ээр ажлын хэсэг ирж манай байгууллагын хүний нөөцийн мэдээллэл, гүйцэтгэлийн төлөвлөгөө, хяналт шинжилгээ үнэлгээний багийн ажил, гүйцэтгэлийн үр дүн, санхүү бүртгэл, бичиг хэрэг, архив, албан хаагчдын хувийн хэргийн бүрдэл зэргийг шалгасан.

- “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн төсөл”-ийг албан хаагчдад танилцуулж холбогдох заалтуудад санал авч, аймгийн ЗДТГ-ын ХЭЗХэлтэст хүргүүлхээр ажиллаж байна.

- Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас ирүүлсэн 21 аймгуудаар газар зохион байгуулалтын албаны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлын удирдамжын дагуу 2021 оны 09 дүгээр сарын 06-09 хооронд манай аймагт ажиллах тул бэлтгэл ажлыг хангуулж байна.

Шүүхийн мэдээлэл:

- Нэхэмжлэгч “Шинэ үе хамтын холбоо” нэхэмжлэлтэй, хариуцагчаар Аймгийн Засаг дарга, хамтран хариуцагчаар ГХБХБГ-ын дарга нарт холбогдох Дархан-Уул аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхэд Хариуцагч нарын зүгээс шүүх хуралдаад оролцогчдын бүрэлдэхүүнийг хангуулах, шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцож чадахгүй болсны дагуу шүүх хуралдааны хойшлуулах үндэслэлээ хүргүүлсэн. Шүүх хуралдааны тов 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 14:00 цагт болж хойшлуулсан.

Мэдээлэл технологийн чиглэлээр:

Мэдээлэл:

1. 70376471 нээлттэй утсаар 19 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв.
2. Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Facebook хуудсанд иргэнээс асуусан 3 асуултанд хариулсан.
3. Улаан загалмайн гишүүн байгууллагын хураамжийг албан хаагчдаас цуглуулж, Улаан загалмайн данс руу шилжүүллээ.



Байгууллагын цахим хуудсанд 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал авах тухай, Дархан суманд газар эзэмшүүлэх дуудлага

худалдааг цахимаар зохион байгуулах тухай зар, Дархан суманд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтын тухай зар, цахимаар үзүүлэх үйлчилгээний мэдээлэл, Дүүжин гүүрийг будсан тухай мэдээлэл, Барилгын үнэ ханшийн талаарх тухай мэдээллийг байрлуулав.

1. Байгууллагын Facebook хуудсанд 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал авах тухай, Дархан суманд газар эзэмшүүлэх дуудлага худалдааг цахимаар зохион байгуулах тухай зар, Дархан суманд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтын тухай зар, цахимаар үзүүлэх үйлчилгээний мэдээлэл, Дүүжин гүүрийг будсан тухай мэдээлэл, Барилгын үнэ ханшийн талаарх тухай мэдээллийг байрлуулав.





2. Серверийн өрөөний кондишны илүүдэл усыг өдөр бүр асгаж, серверийн өрөөнд цэвэр агаар оруулав.

3. Байгууллагын интернэт тасрахад Юнивишн компани руу ярьж дуудлага өгөн засварлуулав.





4. Үндэсний Дата Төв рүү байгууллагын цахим шуудангийн хэрэглэгчид устсан талаар мэдээлж засварлуулан, 3 хэрэглэгчийн цахим шуудангийн нууц үгийг сэргээж өгөв.



5. Албан хэрэг хөтлөлт, архивын асуудал хариуцсан мэргэжилтний компьютерт тоон гарын үсгийн төхөөрөмжийн програмыг суулган, тохиргоог хийж, абле систем дээр туршиж ашиглахад бэлэн болгов.

6. Linux NDG Essentials-ын 6-9-р бүлгийг уншиж, тэмдэглэл хөтлөн, лабораторийн ажлуудыг зааврын дагуу гүйцэтгэж, шалгалтыг өглөө.



Нярав:

1. 70 ширхэг Нэгж талбарын хувийн хэргийн хавтас нугалж, мэргэжилтнүүдэд олгоход бэлтгэв.
2. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд дараах үнэт цаас тус тус олгов.

Сумд	Кадастр	Газар эзэмших /Иргэн/	Газар эзэмших /ААНБ/	Газар эзэмших /ТБ/	Газар ашиглах /ААНБ/	НТХХ
Дархан	522	45	5	1		40
Хонгор						
Орхон						105
Шарын гол						

3. Шаардах хуудсаар 16 төрлийн 36 ширхэг бараа материал олгов.
4. 7-р сарын үнэт цаас болон бараа материалын зарцуулалтын нэгтгэлийн тайланг гаргаж ня-бо-д өгөв.
5. Орхон сумын газрын даамлуудын ирүүлсэн үнэт цаасны зарцуулалтын тайланг тулгаж шалган, хүлээж авав.

Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар:

ГХБХБГ-т 2021 оны 7 сарын 21-ний өдрөөс 8 сарын 20-ны өдрийн хооронд абле программд нийт 94 албан бичиг /хариутай 76/, 23 өргөдөл /хариутай 23/ ирсэнээс 31 албан бичиг, 5 өргөдөл шийдвэрлэн, 45 албан бичиг, 18 өргөдөл хяналтанд бүртгэжээ.

Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:

График 1. Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлт, хяналтанд авч судлаж буй талаарх мэдээлэл





Тайлбар: ГЭЗХХШХ-н 4 албан хаагч ковид-19 өвчний халдвар авсан, хэвтэн эмчлүүлж байгаагийн улмаас 8-р сарын ГЭЗХХШХ хийгдээгүй, 8-р сард хүлээн авсан өргөдлийг хурлаар хэлэлцүүлээгүй байна. Иймд хяналтанд байгаа өргөдлийн тоо 18 байгаа болно.

Архив, бичиг хэрэг:

1. Иргэдээс ирүүлсэн өргөдөл 12 ширхэг, ААНБ-уудаас ирсэн албан бичиг 53 ширхэгийг албан хэрэг хөтлөлтийн Able системд бүртгэж байгууллагын даргаар цохуулан мэргэжилтнүүдэд тарааж өгөв.
2. Байгууллагын мэргэжилтнүүдийн шийдвэрлэсэн өргөдөл 4 ширхэг, албан бичиг 52 ширхэгийг албан хэрэг хөтлөлтийн Able системд шийдвэрлэгдсэнээр бүртгэн хааж, хураав.
3. Байгууллагаас бусад байгууллага болон иргэдэд илгээж буй албан бичиг 37 ширхэг, байгууллагын даргын тушаал 1 ширхэгийг бланкан дээр буулгаж, илгээв.
4. Шүүхээс НТХХ-т үзлэг хийхэд, шаардсан материалыг архиваас гаргаж өгөн, хуулбарлаж, хуулбар үнэн тамга дарж өгөв.

Онцгой байдлын мэдээлэл:

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчдыг 30 хувиар ажлын байранд ажиллуулж, 70 хүртэлх хувийг гэрээсээ ажиллахаар хуваарь гарган, мөрдөн ажиллаж байна /хуваарийг хавсралтаар хүргүүлэв/.
- Байгууллагын байранд нийт 5 тасалгаа байгаагаас 2 тасалгаанд тус бүр нэг албан хаагч, мөн 2 тасалгаанд тус бүр 2 албан хаагч ажиллаж байна. Үлдсэн нэг тасалгаа нь иргэдэд үйлчлэх танхим байрладаг бөгөөд 10 албан хаагч ажиллаж байгааг 30 хувиар ажиллах хуваарийн дагуу өдөрт 4 хүн ажиллахаар зохион байгуулаа.
- 30 хувиар ажиллах хуваарийн дагуу ажиллахад тухайн өдөрт 30 хүртэлх хувьд тохирсон төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх боломжтой байна /цахимаар үзүүлэх үйлчилгээний жагсаалтыг хавсралтаар хүргүүлэв/.

- Ээлжээр ажиллах хуваарь, ажлын байранд үзүүлэх үйлчилгээний хуваарь, цахимаар үзүүлэх үйлчилгээ, мэдээлэл авах 70376483, 70376471 утсыг байгууллагын фэйсбүүк хаяг, байгууллагын гадна байршууллаа.

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021.06.15-ны өдрийн 01-04/05 дугаар албан даалгаврын хүрээнд цахимаар үзүүлэх үйлчилгээний жагсаалт, хариуцсан албан хаагчийн мэдээлэл

2021.06.18-2021.06.30

№	Тэрийн үйлчилгээний төрөл	Хариуцсан албан хаагчдын нэр, утасны дугаар	Цахимаар үзүүлэх боломжтой үйлчилгээ /Хүлээлгэж өгөхгүй/	Ажлын байрны 30 хүнтэй ажилтан хуваарьт өдөр
1	Газар зөвшөөрөх, зөвшөөрөх эрхийн гэрээ, гэрчилгээг шинэчлэх, кадастрын мэдээллийн сан бүртгүүлэх	Аминд ерөн сунд гаргах Э.Гүрванд - 94114640 Үйлдвэрлэл, үйлчилгээ Б.Баярмаа - 99889695	1. Жагсаалтын дагуу материал бүрдүүлж, 2. Ажлыг гүйцэтгэх материалуудыг ГХБХБГ-т авчирч өгөх	Э.Гүрванд - 1, 3, 5 дахь, Б.Баярмаа - 2, 4 дахь өдрүүдэд материал хүлээн авах боломжтой
2	Газар зөвшөөрөх, зөвшөөрөх эрхийн гэрээ, гэрчилгээг хаах үндэслэлтэй тохиолдолд мөнх авах			
3	Газар зөвшөөрөх зөвшөөрөх эрхийн хугацаа сунгуулах			
4	Газар зөвшөөрөх эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх			
5	Хамтран өмчлөгч хасуулах, нэмүүлэх	Э.Гүрванд - 94114640		
6	Хамтран өмчлөгч хасуулах, нэмүүлэх			
7	Сүүлд зөвшөөрөл байгаа газрыг өмчлөх авах			
8	Өмчлөлийн газрыг бусдад шилжүүлэх, хуваалцах	Б.Баярмаа - 99889695	1. Жагсаалтын дагуу материал бүрдүүлж, 2. Эх хувь материалуудыг ГХБХБГ-т авчирч өгөх	
9	Газар өмчлөх аваагүй тодорхойлт авах			
10	Газар эзэмшсэн байгууллагын төлөвлөгөөнд санал өгөх		Шийдвэр гаргах эсэх нь болон өдөлгөөн дэлгэрэнгүй мэдээлэл хүсэлт өгөх	
11	Газар эзэмшигч, эзэмшлэгч, өмчлөгч кадастрын зураг авах	Б.Менхчулуун - 99999990	Газрын гэрчилгээг эх хувиар авч ирэх /100190029003 данснд 2500 төгрөг тушаасан байх, Утга: нэр, регистр/	1, 3, 5 дахь өдөр материал хүлээн авах боломжтой
12	Түсгай зөвшөөрөлтэй эх ахуй нэгж байгууллагын хийсэн геодезм, зураг зүйн болон кадастрын камералтын ажлийг шалгаж хүлээн авах, мэдээллийн сан бүртгэх		Холбогдох материалыг эх хувиар авч ирэх	
13	Газрын эзэмшлийн хэмжээг хийхтэй холбоотой мэдээлэл авах		Газрын гэрээ, гэрчилгээ, кадастрын зургийг эх хувиар авч ирэх	

- Гэрээсээ ажиллаж байгаа болон ажлын байран дээр ажиллаж байгаа албан хаагчид 7 хоног бүрийн пүрэв гаригийн 17:00 цагт ажлын тайланг Хууль эрх зүй, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэнд өгч, нэгтгэн, баасан гаригт байгууллагын даргад тайлагнаж, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлж ажиллахаар зохион байгуулсан.
- Албан даалгавар гарсанаас хойш манай байгууллагад ямар нэгэн хурал, цуглаан, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа хийгдээгүй байна.
- Албан хаагчдаас ямар нэг олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулсан, оролцсон зөрчилгүй болно.
- Албан хаагчдад аймгийн Засаг даргын 2021 оны 01-04/05 дугаар албан даалгаврыг танилцуулж, гарын үсэг зуруулж баталгаажууллаа /гарын үсэг зуруулсан жагсаалтыг хавсралтаар хүргүүлэв/
- Ажлын байранд ариутгалыг тухай бүр хийж байна.

ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ЗОЛБАЯСАХ

ХЯНАСАН:

ГАЗРЫН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Г.НЯМДОРЖ